

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.12.10

Чингис хот

Тус хэлтсийн хамт олон нь улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд шударга, ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх, бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хангах зорилгыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Тус хэлтсийн ёс зүйн зөвлөл нь хэлтсийн даргын 2021.03.01-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2021 онд хийх ажлын 13 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. 2021.03.19-нд ZOOM-ээр сумдын улсын бүртгэгч нарт “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг presentation хичээл хэлбэрээр дахин танилцуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн баталгааны хуудасны загвар боловсруулж улсын бүртгэгч нарт хүргүүлж бүх албан хаагчаас баталгааг гаргуулан авч баталгаажуулан хувийн хэрэгт хавсаргаад байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний стандарт, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг хангах зорилгоор тус хэлтсийн үйлчилгээний зааланд үнэлгээний төхөөрөмж АЗДТГ-аас суурилуулсан. Улсын бүртгэгч бүр үйлчилгээ үзүүлсний дараа үйлчлүүлэгчдээс төхөөрөмжөөр үнэлгээ авч байна. Тайлант хугацаанд төхөөрөмжөөр нийт 1216 иргэнээс маш сайн-1037, сайн-167, дунд-3, муу-9 гэсэн үнэлгээ өгсөн байна. Мөн байгууллагын цахим хуудаст “Ёс зүйн зөвлөл” цэс үүсгэн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл тавьж байна. Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу 1 албан хаагчийг ёс зүйн зөвлөлийн хурлаар оруулж протоколоор сануулсан.

Тайлангийн хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой 88 өргөдөл, хүсэлт ирсний 51 нь иргэдээс, 37 хэлтсийн албан хаагчдаас ирсэн байна. Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу 100 хувь шийдвэрлэж хариу өгч ажилласан.

-Хэлтсийн улсын бүртгэгч нарын санал хүсэлтийн дэвтрээр нийт 94 тэмдэглэл бичигдсэнээс 92 талархал, 2 гомдол байв. Гомдлыг шалгаж үзвэл Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 6-т заасныг зөрчиж өөр иргэний

улсын бүртгэлтэй холбоотой лавлагааг авах талаар хүсэлт гаргасан иргэн байсан. АЗДТГ-ын тусгай дугаарын **70563111** утсаар ирүүлсэн 2 иргэний өргөдлийн хариуг шийдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 21 сонгогчийн мэдээллийг нягтлан тулгаж, тайлбарыг албан бичгээр хүргүүлсэн. МУЕрөнхийлөгчийн сонгуулиар Burtgel.gov.mn хаягаар СНЖ-тай холбоотой ирүүлсэн 23 иргэний гомдлын дагуу мэдээллийг тулган шалгаж холбогдох иргэдтэй утсаар холбогдон тайлбарыг авч шийдвэрлэн илтгэх хуудсыг УБЕГ-т хүргүүлсэн.

Онлайн сүлжээнд холбогдсон Хурх тосгоны улсын бүртгэгч, Мөрөн сумын улсын бүртгэгчийн хүүхэд асрах чөлөө дуусгавар болж ажилдаа орсонтой холбогдуулан, Дадал сум, Өлзийт тосгоны улсын бүртгэгч шинээр томилогдсонтой холбогдуулан программын дадлагажих ганцаарчилсан сургалтыг 4 удаа ажлын байранд нь зохион байгуулж, программын болон хууль эрх зүйн зөвлөгөөг өгч ажилласан. Өмнөдэлгэр сумын улсын бүртгэгч жирэмсний амралт авч байгаатай холбогдуулан Жаргалтхаан сумын улсын бүртгэгчийг ажил үүргийг түр хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргуулж бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулсан. Мөн Биндэр сумын улсын бүртгэгч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Батширээт сумын улсын бүртгэгчид албан үүргийг түр хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргуулж бүртгэлийн үйлчилгээг хэвийн явуулж байна.

Тайлант хугацаанд улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэлийг улсын бүртгэгч, холбогдох албан хаагчид 18 удаа албан бичгээр хүргүүлсэн. Өдөр тутамдаа улсын бүртгэгч нарын үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөөг өгч, ИУБГ-аас өгсөн нэгдсэн чиглэл, зөвлөмжийг 35 удаа цахимаар болон утсаар тайлбарлан мэдээллээр ханган ажилласан. Сумдын улсын бүртгэгч нарт 13 удаа онлайн сургалт зохион байгуулж, сургалтаар сонгуулийн тухай хууль, ИУБГ-аас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, цаг үеийн ажлын талаар танилцуулж мэдээлэл өгсөн.

Улсын ахлах бүртгэгч АЗДТГ-ын Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт 3 удаагийн онлайн, “Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг чадавхижуулах” 1 удаагийн, “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага” сэдэвт танхимын сургалтад тус тус хамрагдсан.

Хэлтсийн 2021 онд зохион байгуулах иргэд, байгууллага болон хэлтсийн албан хаагчдад зориулсан мэдээлэл, сургалтын ажлын төлөвлөгөөнд хэлтсийн албан хаагчдын манлайлал, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр дотоод сургалтыг зохион байгуулах ажлууд байсан боловч дэлхий дахинд гарсан COVID-19 халдварт цар тахлаас шалтгаалан сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах ажил 100 хувь хэрэгжээгүй. Хүний эрхийн шинжээч Д.Эрдэнэбаясгаланг урьж хэлтсийн албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр онлайн сургалт зохион байгуулсан.

ТАЙЛАН БИЧСЭН:

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Ш.МӨНХЗУЛ